

ДУНДГОВЬ АЙМГИЙН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Дундговь аймаг нь 7 сая 469 мянган га нутаг дэвсгэртэй. Үүний 95,2 хувь буюу 7 сая 117.5 мянган га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлдгийн 7 сая 114.5 мянган га буюу 99,9 хувь нь бэлчээр юм.

Газрын нэгдмэл сангийн тайланд аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газарт учирсан хохирол бүхий нийт талбай 1 сая 731,9 мян.га талбай тоологдсоноос 1 сая 728,4 мян.га бэлчээрийн талбай 99,8% эзэлж байна. Үүнээс 1 сая 292 мян.га талхлагдсан, 90900 га салхины эвдрэлд өртсөн, 71000 га элсний нүүдэлд орсон, 350900 га мэрэгч болон хортон шавьжинд өртсөн, 13000 га цөлжсөн, 2784,5 га ашигт малтмал олборлолтонд өртөн доройтсоныг тус тус дурьдсан байдаг.

Аймгийн хэмжээнд өвөл-хаврын, зун-намрын гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэр зонхилдог боловч бэлчээр сэлгэх ойрын болон алсын отор нүүдэл хийх байдал үндсэндээ орхигдон бэлчээрийг жилийн туршид ашиглаж байгаа нь цэгэн талхлагдалт үүсгэх, бэлчээрийн хортон мэрэгч ихээр тархсанаас нийт бэлчээрийн талбайн 21,1 хувь буюу 1,5 сая га бэлчээр доройтоод байна. Мөн сүүлийн жилүүдэд ашигт малтмалын эрэл хайгуул, ашиглалтаас багагүй хэмжээний бэлчээр нутаг эвдрэлд орж, том оврын автомашины зам бэлчээрийн хомсдолд нөлөөлж байна.

Бэлчээрийн даацын хувьд 2009 оны жилийн эцсийн малыг хонин толгойд шилжүүлэхэд 2,7 сая буюу 100 га-д 38 толгой мал, 2009-2010 оны ган, зудын дараа үлдсэн малыг хонин толгойд шилжүүлэхэд 1,9 сая буюу 100 га-д 27 толгой мал ноогдож байгаа нь улсын дунджаас 1,5-2,2 дахин бага байсан.

2017 оны жилийн эцсийн малыг хонин толгойд шилжүүлэхэд 4,9 сая толгой буюу 100 га-д 69 толгой мал байгаа нь улсын дунджаас илүү байгаагийн зэрэгцээ бэлчээрийн талбайн хэмжээ жилээс жилд буурсан үзүүлэлт гарч байна.


Жил бүр өвөл хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа багийн нутгаар тооцоолон жил бүр гаргаж байна.

2018 онд аймгийн УЦУОШТөв, сумдын цаг уурын өртөөний техникч, харуулын ажиглагч нартай хамтран хийгдсэн бэлчээрийн төлөв байдлын судалгааны дүн:

Тус аймгийн нийт нутгийн **15 орчим** хувь нь бэлчээрийн нөөцтэй, **30 гаруй** хувь нь бэлчээр хүрэлцээтэй учир мал өвөлжилт хаваржилт хэвийн байх боломжтой, харин нутгийн **55** хувь нь өөрийн сумын нутагт мал сүргээ онд оруулах бэлчээрийн боломж муу байгаа нь өөр нутагт отор нүүдэл хийх, нэмэгдэл тэжээл бэлтгэх, малын тоог бууруулах зэргээр мал өвөлжилт, хаваржилтын ажлыг эртнээс анхаарах, зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Хулд сумын хойд хэсэг бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрч гарсан, Дэлгэрхангай, Өндөршил, Гурвансайхан сумдын зүүн хэсэг, Говь-Угтаал, Эрдэнэдалай, Луус сумд,

Адаацагийн хойд, урд тал, Дэлгэрцогтын баруун, урд тал, Сайхан-Овоо, Хулд, Дэрэн, Цагаандэлгэр сумдын баруун, зүүн тал, Сайнцагаан сумын зүүн талаас бусад нутаг буюу нийт нутгийн 55 хувь даац 1-3 дахин хэтэрсэн тул мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй (Бэлчээрийн даацын зураг, 2018 оны 8 дугаар сарын 24) байна.



Жил ирэх тусам малын тоо толгой нэмэгдэж, бэлчээрийн ургацын хэмжээ буурч, бэлчээрийн усан хангамж муу, мал сүрэгт зориулсан худгийн тоо цөөрч, ашиглалт нь буурч байгаа нь бэлчээрийн даацад нөлөөлж байна.

4-5-р сард Хулдын хойд талаар орсон борооны чийгээр гарсан ногоог тал бүрээсээ дайрч талхалсан учраас Бэлчээрийн даацын 2018 оны 8 дугаар сарын 24 зураг дээр аймгийн хэмжээнд бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн нутаг болсон байна.

Эндээс үзэхэд түрүүлж бороо орсон 4-5-р сард гарсан ногоог тал бүрээсээ дайрч талхалсаны хор уршигийн улмаас цаашид адилхан бороо орсон бусад зэргэлдээх нутгаас газрын гарцаар их дутуу гарч талхалагдсан даац хэтэрсэн хэвээр үлдэж өвлийн бэлчээргүй нутаг болж үлдсэн байна.

Манай аймагт жилд орох хур тунадасны хэмжээ багасахын зэрэгцээ, хурц нартай өдрийн давтамж, тоо ихэсснээр зун, намартаа гандаж, бэлчээрийн ургацын хэмжээ, ургамлын төрөл зүйлд ихээхэн өөрчлөлт орж, хуурайшилт, хөрсний эвдрэл, элсний бүрхэвч нийт нутгийг хамраад байна.

Иймээс аймгийн хэмжээнд бүх сумдын малчдыг бэлчээр ашиглагчдын хэсгийн зохион байгуулалтанд оруулж, урамшууллын механизмыг бий болгон малчдын оролцоотойгоор бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах нь илүү үр дүн гарна гэж үзэж байна. Түрүүлж ногоо гарсан хэсэгхэн бэлчээрийг талхалуулснаас цаашдаа өвлийн

бэлчээрийн даацад онц муугаар нөлөөлж байна. Ийм учраас түүнийг хамгаалж ямарч зохицуулалтгүй дайрч талхлахаас хамгаалах шаардлага үүсч байна.

Хоёр. Журмын зорилго, зарчим, хэрэгжүүлэх арга зам

Бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөвлөх, зохион байгуулах, хяналт үнэлгээ хийх замаар бэлчээрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, бэлчээрийн нөөц чадавхид тохируулан мал сүргээ маллах, өсгөх, малчдыг урамшуулах эдийн засгийн хөшүүрэг бий болгон аймгийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахад журмын зорилго оршино.

2.1. Журмыг хэрэгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавхад суурилсан, оролцогсдын тэгш оролцоог хангахад дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:

- ✓ Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт үнэлгээ хийх, зохистой ашиглах хамгаалах, олон настын үр тарьж аюулгүй нөөц бүрдүүлэх, сэлгэж өнжөөх, амраах арга хэмжээг малчдын оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлнэ.
- ✓ Бэлчээрийн экологийн чадавх, бүтээмжит чанар, даацад нь нийцүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэнэ.
- ✓ Улирлын бэлчээр, бэлчээр дэх бусад нөөц (хужир мараа, байгалийн усны ил эх үүсвэр)-ийг ашиглахад оролцогсдын тэгш байдлыг хангана. Цаг улирлын болон тухайн үеийн бэлчээрийн даацаас хэтрүүлж мал оруулахыг хориглоно.
- ✓ Гэргүй өрхийн малыг тухайн амьдарч буй өрхөд оруулан тооцно. /утаат өрх/

2.2. Бэлчээр ашиглалтын чиглэлээр сар улирал жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ дор дурдсан зохицуулалтыг баримтална. Үүнд:

- ✓ Бэлчээр ашиглалтын талаар тухайн сар улирал жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, БИНХурлаар хэлэлцүүлнэ. Хэрэв хавар зун, намрын сар улиралд хэсэгчилэн орсон хур тундасны мөрөөр хэсэгхэн ургасан ногоо бэлчээрийг зохистой ашиглах талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг сумын ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Шаардлагатай бол Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд оруулж гаргасан шийдвэрийн дагуу сум, багийн удирдлага зохицуулж хяналт тавьж хэрэгжүүлнэ.
- ✓ БИНХ-аар батлагдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэс болно.
- ✓ Бэлчээр ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хөтөлбөрийн байгууллагууд малчдын бүлэг, БАХ-н чиглэлээр бэлчээр ашиглалтын төлөвлөгөө

гарган төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

- ✓ Бэлчээрийн даацаас хэтэрсэн нэг хонин толгой тутмаас 500 хүртэлх төгрөгний төлбөр авч “Бэлчээрийн сан”-д төвлөрүүлнэ.
- ✓ Тухайн жилд өнжөөж, чөлөөлөх болон отрын бүс нутгийг сумын Засаг дарга өргөн мэдүүлснээр ИТХ шийдвэрлэнэ.

Гурав. Бэлчээрийн төлөв байдлыг хянах, бэлчээрийн даац тооцох

3.1. Сумын засаг даргын тамгын газар бэлчээрийн даацад үндэслэсэн дараах тооцооллыг гаргаж жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор багийн Засаг даргад зөвлөмж байдлаар хүргүүлнэ. Үүнд:

3.1.1. Хонин толгойд шилжүүлснээр өвөлжих малын тооны дээд хязгаар N^{\max} -ыг тогтоох:

$$\frac{N^{\max} \text{ Өвөлжиж хаваржих малын тооны дээд}}{\text{бэлчээрийн нийт ургацын хэмжээ}} = \frac{180 \text{ хоног} * 1,1 \text{ кг}}{}$$

3.1.2. Тухайн багийн малчин өрхийн нэг гишүүнд ногдох малын тоо толгойг тогтоох

$$\frac{\text{Малчин өрхийн 1 гишүүнд ногдох малын}}{\text{өвөлжих малын тооны дээд хязгаар}} = \frac{\text{багийн нийт малчин өрхийн тоо}}{}$$

3.2. Багийн засаг дарга нар энэ журмын 3.1-д заасан зөвлөмжид үндэслэн тухайн сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төсөлд дор дурьдсан асуудлыг тусгуулахаар гаргаж тухайн оны 10 дугаар сарын 01-ны дотор багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.2.1. Малчин өрх тус бүрийн өвөлжүүлэх малын тооны дээд хязгаар тогтоох

Аргачлал нь:

$$\begin{array}{l} \text{Малчин өрх бүрийн өвөлжүүлэх} \\ \text{малын тооны дээд хязгаар} \end{array} = \begin{array}{l} \text{өрхийн нэг} \\ \text{гишүүнд ногдох} \\ \text{малын тоо толгой} \end{array} * \begin{array}{l} \text{тухайн өрхийн} \\ \text{гишүүдийн тоо} \end{array}$$

3.2.2. Журмын хүрээнд бэлчээрийн хөрөнгө оруулалтаас чөлөөлөгдөх болон төлбөр хийх малчдын нэрс

3.2.3. Бэлчээрийн даацаас илүү гарсан хонин толгойд шилжүүлсэн малын тоо толгойд ноогдох төлбөрийн хувь хэмжээ /төгрөгөөр/

3.2.4. Бэлчээрийн даац хүрэлцээтэй нөхцөлд өөр аймаг, сумаас өвөлжиж, хаваржиж болох малын тооны дээд хязгаар

3.3. Багийн иргэдийн нийтийн хурал нь энэ журмын 3.2-т заасан асуудлыг жил бүрийн 10

3.4. дугаар сарын 15-ны дотор хэлэлцэж сумын Засаг даргад хүргүүлнэ.

- 3.5. Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн иргэдийн нийтийн хурлын саналыг тусган Газрын тухай хуулийн 52.1-д заасны дагуу харьяалах сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал батлана.
- 3.6. Бэлчээрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улс, донор байгууллагын төсөл хэрэгжүүлэгч нэгж бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллаж болно.

Дөрөв . Журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1 Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар:

4.1.1. Бэлчээр ашиглагчид, малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулан бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгоход туслах.

4.1.2. Багийн иргэдийн Нийтийн хурлын саналыг харгалзан дэмжигдсэн бэлчээрт усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

4.1.3. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг бэлчээр ашиглагч малчин өрхийн оролцоотой зохион байгуулах.

4.1.4. Фото мониторингийн дүнд тулгуурлан тухайн жилд малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сүргийн зохистой бүтэц, харьцаа, шилэн сонголт, чанар болон МАА-г үр ашигтай эрхлэн явуулах, гаргах, бусад асуудлаар зөвлөмж гаргаж хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

4.2. Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв:

4.2.1. Тухайн сумын бэлчээрийн төлөв байдлын ажиглалтыг 08 дугаар сарын 10-наас 20-ны дотор сум, баг, бэлчээр ашиглагчдын холбоодын оролцоотойгоор цаг уурын шинжилгээний өртөө, харуулын техникч, ажиглалгч нар шугаман цэгийн бичиглэлийн аргаар хийж бэлчээрийн даацыг тодорхойлсноор, өвөлжиж хаваржих боломжтой малын тооны талаар холбогдох үнэн зөв мэдээллээр хангана.

4.2.2. Бэлчээр хүрэлцээгүй газарт үүлэнд зориудаар нөлөөлөх

4.2.3. Багийн ИНХ-аас саналыг үндэслэн шаардлагатай гэж үзвэл газрын генератор байршуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.

4.2.4. Аймгийн УЦУОШТөв нь Сансарын хиймэл дагуулаас авсан ургамлын бүрхэвчийн индексжүүлсэн мэдээг тайлал хийж дулааны улиралуудад орсон борооны мөрөөр сэргэсэн бэлчээрийн талбайн хэмжээ, даац болон хонин толгойд шилжүүлсэнээр

хичнээн тооны мал ямар хугацаагаар бэлчээрлүүлж болохыг тодорхойлж шугаман болон фотомониторингийн хэмжилтээр баталгаажуулна. Харин захиалагч хэн байхыг хөрөнгөний эх үүсвэрийн хамт журамд тодорхой зааж өгнө.

4.3 Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар,

4.3.1. Улирлын болон нөөц бэлчээрт жил бүр фото мониторинг хийж, олон жилийн дундажтай харьцуулан, энэ журмын 6.1-д заасан бэлчээр ашиглагчдын хэсэг, малчин өрх, орон нутгийн удирдлагад мэдээлэх.

4.3.2. Энэ журмын 6.1-д заасан бэлчээр ашиглагчдын хэсэг багийн тухайн жилд хийсэн ажлыг дүгнэх, дараа жилийн ажлыг төлөвлөхөд фотомониторингийн дүнг ашигладаг болгон хэвшүүлэх.

4.3.3. Сумын нөөц бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах.

4.3.4. Газрын тухай хуулийн 58.5-д заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

4.3.5. Бэлчээр ашиглалтын гэрээг байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргах.

4.3.6. Бэлчээр ашиглалтын гэрээг газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх:

4.3.7. Фото мониторингийн дүнд үндэслэн гэрээний хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах.

4.3.8. Өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгийн байршлыг тогтоож мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх.

Тав. Бүх шатны хурал, засаг даргын болон малчдын чиг үүрэг

5.1 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг:

5.1.1. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг хэлэлцэн баталж, доод шатны засаг дарга нарт үүрэг даалгавар, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

5.1.2. Журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж байгаа иргэн, малчдын бүлэг, хоршоо хэсэг-т давуу эрхээр улсын төсөв болон ОНХСангаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төрийн дээд одон медальд тодорхойлно.

5.1.3. Аймгийн засаг даргын өргөн мэдүүлснээр сум дундын отрын нөөц бэлчээрийг тогтооно.

5.2 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг:

5.2.2. Сумын хэмжээнд хэрэгжүүлэх “Бэлчээрийг хариуцлагажуулах нэгдсэн журам”-ыг мөрдүүлэх.

5.2.3. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй иргэн, малчдын хэсэгт хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

5.3 Багийн иргэдийн нийтийн хурлын чиг үүрэг:

5.3.1. “Бэлчээрийн сан”-ийн хөрөнгөөр тухайн жилд хийж гүйцэтгэх, арга хэмжээний саналыг хэлэлцэж батлах.

5.3.2 Бэлчээрийн сан бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавих.

5.3.3. Багийн бэлчээрт фотомониторинг хийх цэгийн тоог тогтоох.

5.3.4. Жил бүрийн 05 сарын 01 дотор хуралдаж, өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

5.4 Аймгийн Засаг даргын чиг үүрэг

5.4.1. Сумын засаг даргын ажлын үнэлгээнд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийн үр дүнг харгалзан үзэх.

5.4.2. Гантай болон өвөлжилт хүндэрсэн сум, багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй сум багийн нутаг дэвсгэрт айл өрх, мал сүргийг тухайн сумын Засаг даргатай зөвшилцөн оруулах.

5.4.3. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг үлгэр жишээ сайн мөрдөн хэрэгжүүлж байгаа сум багт давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх.

5.4.4. Бэлчээрийн даацаас хэтэрсэн мал болон түүхий эд, бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

5.4.5. Улс, Аймгийн аварга малчин, тэргүүний хамт олныг шалгаруулахдаа бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтийг харгалзах.

5.4.6. Сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээр нэмэгдүүлэх, цаг хүндэрсэн үед ашиглах арга хэмжээг бэлчээрийн нөөц, чадавхид тохируулан зохион байгуулах.

5.5 Сумын засаг даргын чиг үүрэг:

5.5.1. Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох.

5.5.2. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

5.5.3. Багийн засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр менежментийн төлөвлөгөө, бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийн үр дүнг үндэслэн дүгнэх.

5.5.2. Бэлчээр ашиглалтын гэрээний үүргээ биелүүлж ажиллаж байгаа, баг, малчин өрхөд давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх.

5.5.4 Төсвийн хуулийн 58.4 заалтын дагуу Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөлтийг хийх зардлыг сумын жилийн төсөвт тусган дулааны улиралд хэсэгчлэн сэргэсэн бэлчээрийг зүй зохистой, үр ашигтай ашиглахтай холбогдсон зардлыг санхүүжүүлж ажиллана.

5.5.5. Багийн ИНХ-ын тогтоолыг үндэслэн малчдын бүлэг, нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэгт Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу бэлчээрийг урт хугацаагаар гэрээгээр ашиглуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага үр дүнг тооцож ажиллах.

5.5.6. Гол, горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд өвөлжөө, хаваржааны ойролцоо нөөц бэлчээр бий болгох зорилгоор 3 хүртэл га бэлчээрийг хашиж хамгаалуулах.

5.5.7. Тухайн сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжиж, хаваржих малыг оруулахдаа журамд заасан хөрөнгийг Бэлчээрийн санд төвлөрүүлсний дараа тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлэх.

5.5.8. Багийн малчин өрхүүдийн хуримтлуулсан төлбөрийг сумын “бэлчээрийн сан”-д төвлөрүүлж тухайн багийн иргэдийн нийтийн хурлаас шийдвэрлэсэн үйл ажиллагаанд зарцуулах.

5.5.9. Аймгийн УЦУОШТөв Сансарын хиймэл дагуулаас авсан ургамлын бүрхэвчийн индексжүүлсэн тайлал хийсэн мэдээллийг /орсон борооны мөрөөр сэргэсэн бэлчээрийн талбайн хэмжээ, даац болон хонин толгойд шилжүүлсэнээр хичнээн тооны мал, ямар хугацаагаар бэлчээрлүүлж болохыг тодорхойлсон/ шинээр сэргэж даац нь нэмэгдсэн хэсэг бэлчээрийг зохистой ашиглах зорилгоор аймгийн УЦУОШТөвд сумдаас захиалгыг өгч, мэдээлэл авах зардлаа хариуцна.

5.5.10.Тухайн бэлчээрийн даацад тохируулан тодорхойлсон малын тооноос одоо үг бэлчээрт бэлчиж байгаа малын тоог хасаад нэмж оруулах малын тоонд тохирсон малтай малчдыг аль усанд бууж хэдий хугацаагаар байж болохыг албан ёсоор мэдэгдэнэ. Энэ тухай

нийт малчдад аюулаас сэргийлэх цогцолборуудыг ашиглан мэдээлж бэлчээр ашиглалтын журмыг танилцуулах.

5.5.11.Зэргэлдээ сумдын Засаг дарга нарт тухайн шинээр сэргэсэн бэлчээрт тухайн сумаас мал нэмж оруулах боломж байгаа эсэхийг албан бичгээр мэдэгдэнэ. Хэрэв мал нэмж оруулахаар бол хэдэн тооны малтай айлыг аль усанд ирж буугаад ямар хугацаагаар байж болохыг албан бичигт тодорхой заах.

5.6 Багийн засаг даргын чиг үүрэг

5.6.1. Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

5.6.3. Тогтоосон төлбөрыг “Бэлчээрийн сан”-д төвлөрүүлэх.

5.6.4. Тухайн жилд бэлчээрийн санд хуримтлагдах хөрөнгийг сумын нэгдсэн дансанд төвлөрүүлэх, БИНХ шийдвэрийн дагуу зарцуулж, тайлагнах.

5.6.5. 5.5.10, 5.5.11. дахь заалтууд, сумын Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэхэд сумын БМАХ, Багийн засаг дарга нар хуваарь гарган хамтран зохион байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж зохицуулна. Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох албан тушаалтан арга хэмжээг авна.

5.7 Малчдын чиг үүрэг

5.7.1. Малчдын бүлэг, нөхөрлөл, БАХ зэрэг хамт олны зохион байгуулалтад нэгдэж бэлчээр ашиглах үйл ажиллагаанд оролцох.

5.7.2. Багийн бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулахад оролцох.

5.7.3. Бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн, үржүүлэх бөгөөд бэлчээрийн даацаас хэтэрсэн малд хонин толгойгоор бодож тогтоосон төлбөрийг хугацаанд нь сумын “Бэлчээрийн сан”д төлж байх.

5.7.4.Бэлчээрийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргах, уг арга хэмжээний явц, гүйцэтгэлд болон сангийн зарцуулалтын байдалд хяналт тавих.

5.7.5. Бэлчээр ашиглалтын гэрээнд заасны дагуу төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын улирлын хуваарьт бэлчээрээс өөр бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх.

5.7.6. Бэлчээр ашиглалтын гэрээнд заасны дагуу бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн үржүүлэх.

5.7.7.Бэлчээрийг өнжөөж, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гарсан шийдвэрийг дагаж биелүүлэх.

5.7.5. Гаднаас дур мэдэж айл өрх, мал сүрэг оруулж ирэх, өвөлжөө, хаваржаа, хонд бууцыг бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэхгүй байх.

5.7.6. Бэлчээрт байгаа малын сэг, зэм, хог хягдлыг тухай бүр устгах, цэвэрлэх.

5.7.7. Дур мэдэж өвөлжөө, хаваржаа барих бэлчээрийг хашихгүй байх.

5.7.8. Бэлчээрийн даацаас хэтэрсэн малтай бол хонин толгойд шилжүүлснээр тооцож 500 хүртэлх тогтоосон мөнгө /цаашид"хөрөнгө"гэх/-ийг Бэлчээрийн санд хуримтлуулах.

Зургаа. Чөлөөлөгдөх нөхцөл

6.1. Тухайн баг сумын нутаг дэвсгэрийн 50-с доошгүй хувь нь гантай байсан нь тогтоогдсон нөхцөлд нийт малчин өрх

6.2. Хонин толгойд шилжүүлснээр өрхийн 1 гишүүнд 200 мал ногдох / тэмээнээс бусад малыг хонин толгойд шилжүүлэн тооцох/

6.3. Тэмээн сүргийн тоо толгойг өсгөж нэмэгдүүлэх, үүлдэрлэг байдал, чанарыг сайжруулах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор тус тус чөлөөлөх.

Долоо. Бэлчээрийн сан, сангийн зарцуулалт

Бэлчээр ашиглагчдын хэсэг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 51.1-д заасныг үндэслэн бэлчээрийг нөхөн сэргээх, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх, гишүүн малчин өрхдөө дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү санг байгуулна.

7.1. Бэлчээрийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

7.1.1. Малчин, мал бүхий өрхийн хөрөнгө оруулалт

7.1.2. Энэ журмын 2.2.4-д заасан хөрөнгө

7.1.3. Бэлчээрийн сан-д нь тухайн багаас хуримтлагдсан хөрөнгийн хэмжээтэй тэнцэх төсвийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө оруулалт хийж дэмжих,

7.1.4. Төсөл хөтөлбөрийн байгууллагын хөрөнгө,

7.1.5. Бусад байгууллага, хамт олны хандив, тусламж

7.1.6. Бусад эх үүсвэр

7.1.7. Өөр аймаг, сум, багаас орж ирсэн малаас авах төлбөрийн дээд хэмжээг хонин толгойд шилжүүлснээр нэг хоногт 10 төгрөгнөөс доошгүй байхаар тооцож бэлчээрийн санд төвлөрүүлэх.

- 7.1.8. Бизнесийн зорилгоор олон тооны мал суурилсан бол нэг хонин толгойд нэг хоногт 50 төгрөгөөр бодож бэлчээрийн санд төвлөрүүлэх.
- 7.1.9. Энэ журмын 6.2.1-д заасан хөрөнгийг бэлчээр ашиглагч малчин өрх дараа оны 05 сарын 15 дотор барагдуулна.
- 7.1.10. Малчин өрхийн маллаж байгаа тавиул малыг тухайн малчин өрхөд оруулж тооцно.

7.2. Сангийн хөрөнгийг зөвхөн дараах зүйлд зарцуулна.

- 7.2.1. Доройтсон, хэт доройтсон бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа /бусад малчдыг эрх ашгийг хөндөхгүйгээр/
- 7.2.2. Ашиглагдахгүй бэлчээрийг ашиглах зорилгоор хөв, цөөрөм, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх,
- 7.2.3. Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх,
- 7.2.4. Газрын генератор суурилуулах, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд /түлш авах, үүлэнд зориудаар нөлөөлөх/,
- 7.2.5. Бэлчээрийг хамарсан мод, бут,сөөг, тариалах,
- 7.2.6. Өөр аймаг сумд отроор яваа малчин өрхөд шаардлагатай бол сангаас дэмжлэг үзүүлж болно.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг Газрын тухай хуулийн 52.10-т заасны дагуу багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

8.2. Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

Ес. Журам хүчин төгөлдөр болох, хүчинтэй үйлчлэх хугацаа

- 9.1. Энэхүү журмыг **батлагдсан өдрөөс** эхлэн дагаж мөрдөнө.
- 9.2. Энэхүү журам нь жил бүрийн 10 сарын 01 өдрөөс 04 сарын 01 өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжинэ.

